

Эмийн аргаар үр хөндөх тухай



Эмийн аргаар үр хөндөх тухай



Та үүнийг мэдэх үү?

Эмэгтэй хүний сарын тэмдэг анх 10 настайд ирсэн гэж тооцвол насан туршид нь нийт 480 удаа ирдэг. Өөрөөр хэлбэл төдий тоогоор жирэмслэх чадамжтай гэсэн үг.

Жирэмслэлт нь урьдчилан тооцож болохуйц үйл явдал тул урьдчилан хамгаалах бүрэн боломжтой.

Гэхдээ хөгжиж буй орнуудын (манайх ч багтана) бэлгийн идэвхтэй насны эмэгтэйчүүдийн тэн хагас нь жирэмслэх төлөвлөгөөгүй байдаг. Харамсалтай нь эдний 17% нь жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл огт хэрэглэдэггүй, 9% нь найдваргүй, үр дүнгүй уламжлалт хэрэгсэл хэрэглэдэг.

Шалтгаан нь бэлгийн боловсролгүй байх, эсвэл жирэмснээс хамгаалах хэрэгсэл хэрэглэх эрх мэдэлгүй байдаг. Үүн дээр нэмэгдэн хүчингийн улмаас жирэмсэлсэн, гэр бүлийн хүчирхийлэлд амьдардаг, нярай болон бага насны хүүхэдтэй, эрүүл мэнд, эдийн засгийн таагүй нөхцөл зэргээр үр хөндүүлэхийг хүсэх шалтгаан өчнөөн.



Аюулгүй үр хөндөлт

Үүнтэй зэрэгцэн эцгийн эрхт соёл, шашин, улс төр зэрэг олон талаас үр хөндөлтийг эсэргүүцдэг. Эсэргүүцлийн үндэслэл хэчнээн итгэж болохуйц байлаа ч бодит байдалд эмэгтэйчүүд үр хөндөлт хийлгэсээр байдаг. Үр хөндөлтийг хуулиар зөвшөөрөхгүй байгаагаас үүдэн үр хөндөлт үргэлж хууль бус, нууц, тэр хэрээрээ эмэгтэйн эрүүл мэндэд аюултай. Сая сая эмэгтэй аюултай үр хөндөлтийн улмаас амиа алдаж, эсвэл нөхөн сэргэх боломжгүй эрүүл мэндийн асуудалтай болсоор буйг олон судалгаа харуулдаг.



Хэзээ, хэнээс жирэмслэх, хэдэн хүүхэдтэй болох зэргээ өөрөө мэдэх нь эмэгтэй хүний бэлгийн болон нөхөн үржихүйн эрх бөгөөд үр хөндүүлэх (нэг болон түүнээс дээш удаа) сонголт нь энэхүү эрхийн салшгүй хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Эрх хэмээн хүлээн зөвшөөрснөөр л энэ эрхийг хангах, хамгаалах хууль зүйн болон эрүүл мэндийн тогтолцоо, үйлчилгээ ажиллана.

Аюулгүй үр хөндөлт

Аюулгүй үр хөндөлт гэдэг нь эрүүл ахуйн стандартад нийцсэн орчинд мэргэжлийн эмч жирэмслэлтийг зогсоох үйл явц. Ингээд зогсохгүй энэ үйлдлийнхээ төлөө хэн, хэн нь хуулийн хариуцлага хүлээхгүй байх баталгаа. Түүнчлэн энэ талаарх мэдээллийг авах боломж нээлттэй байх нөхцөл.

2021 он гарсаар, НҮБ-ын Хүн амын сангийн гүйцэтгэх захирал Др. Наталья Канем "Бодитой мэдээлэлд тулгуурлан хүн бүр өөрсдийн бие махбодьтой холбоотой асуудал, ирээдүйгээ шийдэх эрхтэй болсон цагт олон нийт, улс орон цэцэглэн хөгжинө" гэж мэдэгдсэн.

Охид, эмэгтэйчүүд эрүүл мэнд, бие махбодьтой холбоотой асуудлаа өөрсдөө шийдэж, сонголт хийдэг болсоноор амьдралаа бие даан шийддэг болоод зогсохгүй тэдний эрүүл мэнд, боловсрол, орлого, аюулгүй байдал нь сайжирдаг билээ.



Эмээр үр хөндөх

Эмээр үр хөндөх гэж юу вэ?

Эмээр үр хөндөх гэдэг нь эм, эмийн нэгдлээр жирэмслэлт зогсоохыг хэлнэ.

Хэр найдвартай вэ?

Маш найдвартай! Эмээр үр хөндөх нь бусад аргаар үр хөндөх, хүсээгүй жирэмслэлтийг үргэлжлүүлэхтэй харьцуулахад эрсдэл нь ТУН БАГА. Эхний 12 долоо хоногтоо жирэмслэлт зогсоох эм хэрэглэсэн ЗУУН эмэгтэйн ТАВаас цөөн эмэгтэйд хүндрэл үүсэж эмнэлэгт хандах магадлалтай байдаг. Энэхүү 2 эмний комбинаци гэж нэрлэдэг арга нь Монгол улсад ч хэрэглэж буй.


Жирэмслэлтийн аль үед эмээр үр хөндөж болох вэ?

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын зөвлөмжийн дагуу сарын тэмдгийн мөчлөгийн эхний өдрөөс тоолсноор 24 долоо хоногийн дотор буюу жирэмсний эрт үед эмээр үр хөндөж болно.

Гэхдээ жирэмслэлтийн үе бүрд эмийн тун өөрчлөгддөг бөгөөд 12 долоо хоногоос хойш бол эмнэлэгт хийгдэх ёстой.

Давтан үзлэг хэзээ хийлгэх вэ?

Хэрэв та эмнэлгийн хяналтад байгаа бол эм ууснаас 14 хоногийн дараа давтан үзүүлээрэй. Эмч үзээд үр хөндөлт явагдаж дууссан болон үргэлжлүүлэн эмчилгээ шаардлагатай эсэхийг хэлэх болно.



Жирэмслэлтийн аль үед эмээр үр хөндөж болох вэ?

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын зөвлөмжийн дагуу сарын тэмдгийн мөчлөгийн эхний өдрөөс тоолсноор 24 долоо хоногийн дотор буюу жирэмсний эрт үед эмээр үр хөндөж болно.

Гэхдээ жирэмслэлтийн үе бүрд эмийн тун өөрчлөгддөг бөгөөд 12 долоо хоногоос хойш бол эмнэлэгт хийгдэх ёстой.

Давтан үзлэг хэзээ хийлгэх вэ?

Хэрэв та эмнэлгийн хяналтад байгаа бол эм ууснаас 14 хоногийн дараа давтан үзүүлээрэй. Эмч үзээд үр хөндөлт явагдаж дууссан болон үргэлжлүүлэн эмчилгээ шаардлагатай эсэхийг хэлэх болно.

Хэн эм ууж болохгүй вэ?

Жирэмсний эрт үед доор дурдсан цөөнөөс бусад тохиолдолд эмээр үр хөндөж болно. Үүнд:

- Эмч савны гадуур жирэмслэлт байж болзошгүй гэж үзэж байгаа бол
- Мифепристон, мисопростолоос харшилтай бол
- Цусны бүлэгнэлтэнд нөлөөлөх ямар нэг өвчтэй бол
- Цус шингэлэх эмчилгээ хийлгэж байгаа бол
- Архаг астма, үе мөчний үрэвсэл болон харшил зэргийн үед гормон хэрэглэж байгаа бол
- Мөн жирэмснээс хамгаалах суулгацтай бол авахуулах хэрэгтэй.

Ирээдүйд хүүхэдтэй болох эсэхэд нөлөөлөх үү?

Эмээр үр хөндөх нь ирээдүйд хүүхэдтэй болоход сөрөг нөлөө үзүүлэхгүй. Үүнийг зөвхөн бид хэлээгүй юм шүү! Энэ талаар хийгдсэн судалгаанууд бий!



Үр хөндөлт эхний гурван сард хийсний дараа ямар дашрамын нөлөө гарах вэ?



Цус гарах

Мифепристон уусныхаа дараа хэрэглэх том ариун цэврийн хэрэглэл бэлтгээрэй. Сарын тэмдэг ихээр ирж буй мэт нөжтэй цус гарна.

Өвдөх базлах

Гэрийн нөхцөлд халуун устай сав, халуун бигнүүр тавих, халуун шүршүүрт орох зэргээр өвчин намдааж болно. Мөн биений юм ирсэн үедээ уудаг өвчин намдаагчаа юм уу парацетамол, мефенамикийн хүчил, ибупрофений төрлийн эм ууж болно. Өөр зүйлд сатаарч, завгүй байх нь мөн тус болно.



Жихүүдэс хүрэх, халуурах

Цөөн тохиолдолд, мифепристон уусны дараа бага зэрэг жихүүдэс хүрч, халуурч болно. Энэ нь ихэнхдээ хоёр цагийн турш үргэлжилдэг бөгөөд дулаан хөнжилдөө хэвтэхээс өөр эмчилгээ шаардлагагүй, ноцтой дашрамын нөлөө биш юм.


Дотор муухайрах

Зарим эмэгтэйчүүд их, багаар дотор муухайрдаг. Энэ үед хөнгөн хооллож, шингэн зүйл ихээр уух нь тустай. Харин эм ууснаас хойш 30 минутын дотор бөөлжсөн бол дахин уух шаардлагатай. Шинж тэмдэг хүндэрсэн тохиолдолд эмчээс зөвлөгөө аваарай.



ЭМИЙН АРГААР ҮР ХӨНДСӨНИЙ ДАРАА ЯМАР ХҮНДРЭЛҮҮД ГАРЧ БОЛОХ ВЭ?

1



Их хэмжээгээр цус алдах

Маш цөөхөн тохиолдолд, зарим эмэгтэйчүүд цус алддаг. Их хэмжээний цус алдалт гэдэг нь: нэг цагийн дотор хоёр ширхэг зузаан ариун цэврийн хэрэгсэл дүүрч, нэвтэрч, энэ нь хоёр цагаас дээш үргэлжлэх юм. Энэ тохиолдолд шууд эмчтэй холбогдоорой. Шингэнээ нөхөхийн тулд их хэмжээний шингэн зүйл уусаар байх хэрэгтэй шүү.



Үрэвсэл

Жихүүдэс хүрэх болон бага зэрэг халуурах нь эмээр үр хөндөлтийн дараах дашрамын нөлөө боловч, дөрвөн цагаас дээш хугацаагаар 38 хэмээс дээш халуурах юм уу, мисопростолийг ууснаас хойш халуурсан бол заавал эмчид хандаарай.

2



3



Хэзээ бэлгийн харьцаанд орж болох вэ?

Шавхрага гарч дуустал үтрээгээр бэлгийн харьцаанд орохгүй байх хэрэгтэй. Энэ нь ойролцоогоор 10 хоног үргэлжилнэ. Гэхдээ та өөрийгөө бэлэн гэж үзсэн үедээ л бэлгийн харьцаанд орох нь зөв гэдгийг хэлэх нь илүүц биз ээ!



12 долоо хоногоос (84 хоног) бага хоногтойд эмээр үр хөндөх үед хийгдэх эмчилгээ

Мифепристон болон мисопростол

9 долоо хоног (63 хоног) хүртэлх үед

- ▶ Мифепристониог ууснаас 24-48 цагийн дараа ->
- ▶ 2,5 мисопростолыг 800 микро-грамаар үтрээгээр, амаар, хэлэн доор тавьж хэрэглэх

7 долоо хоногоос (49 хоног) илүүгүй үед

- ▶ Мисопростолыг 400 микро-граммаар нэг удаа амаараа залгиж хэрэглэнэ.

9-12 долоо хоног (63-84 хоног)

- ▶ Мифепристониог ууснаас 36-48 цагийн дараа ->
- ▶ Мисопростолыг 800 микро-граммаар хэрэглээд, дараа нь үтрээгээр 400 микро-граммыг, дараа нь үтрээгээр эсвэл хэлний доор тавьж 3 цаг тутамд, 5 хүртэлх тунгаар хэрэглэнэ.

МИСОПРОСТОЛЫГ ДАНГААР НЬ ХЭРЭГЛЭХ ҮЕД

- ▶ Мисопростолыг 800 микро-граммаар үтрээгээр эсвэл хэлний доор тавьж 3-12 цаг тутамд 3 хүртэлх тунгаар хэрэглэнэ.

Эх сурвалж.

- ▶ Аюулгүй үр хөндөх клиникийн практикийн гарын авлага, ДЭМБ. 2014
- ▶ Бэлгийн цогц боловсрол олгох “Улаан булан” сэтгүүл, Улаанбаатар хот. 2018
- ▶ 2021 оны Дэлхийн хүн амын байдал тайлан, НҮБХАС. 2021

Эмээр үр хөндөх талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл:

- ▶ Safe Abortion: Technical and Policy guidance for health systems by the World Health Organization

Women on Web

- ▶ Medical Abortion by Ibis Reproductive Health and Cambridge reproductive Consultants
- ▶ Medical Abortion: An overview by Gynuity Health Projects

Бидэнтэй цахимаар холбогдохыг хүсвэл:

- Facebook – @AsiasafeAbortionPartnership
- Твитер – @asapasia
- Инстаграм – @safeabortion_asap
- Youtube – ASAPasia
- Цахим хуудас – Asap-asia.org

Эмээр үр хөндөх талаар баримтын хуудас

